

**УИХ-ЫН 2000 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
ЭХ ОРОН-МОНГОЛЫН АРДЧИЛСАН ШИНЭ  
СОЦИАЛИСТ НАМЫН ХӨТӨЛБӨР**

"Эх орон-МАШСН"-ын уриа:  
"Өөртөөт итгэж, өөрсдөөт хийцгээе"

**Хүндэт сонгогчид өө**

*Манай нам тусгаар тогтнол, хүний хөгжлийг дээдлэн, орчин цагийн соёл иргэншилт нийгмийн төлөө ажиллаж байна.*

*"Эх орон-МАШСН"-д улс орноо удирдах боломж олгосноор бид:*

-Дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж, мал аж ахуй, газар тариалан, эрдсийн баялгийг эрчимтэй ашиглах замаар үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлнэ.

-80 мянгаас доошгүй ажлын байр шинээр бий болгох нохицлийг бүрдүүлж, ядуурлыг арилгана.

-Үндэсний эв нэгдлийг бэхжүүлж, ард түмнийхээ өөртөөт итгэх итгэлийг сэргээнэ.

-Эдийн засгийн эрс шинэчлэлийн бодлого явуулж, улс орноо бүсчилэн хөгжүүлнэ.

-Төр засаг, хууль хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, авилга, хуйвалдааныг таслан зогсоно.

**Нэг. Улс орны өнөөгийн байдал**

Сүүлийн 10 жил бол улс орны хөгжил буурч, хүн ардын дийлэнхийн амьжиргаа 5-10 дахин дордсон их уналтын жилүүд байлаа. Монгол төгрөгийн доллартай харьцах хани 360 дахин доошилж, төсвийн алдагдал 100 тэрбум төгрөгт хүрч, гадаад өр 900 сая ам.долларт хүрсэн нь Монгол улсын эдийн засгийн өнөөгийн бодит төрх юм.

Далаад онд хүмүүсийн сарын дундаж цалин 540 төгрөг буюу ойролцоогоор 180 ам.доллар байсан бол одоо төсвийн байгууллагад ажиллагчийн дундаж цалин 40-50 мянган төгрөг болж, 40-50 ам.долларт ч хүрэхээ болов.

200 гаруй мянган хүн ажилгүй болж, бичиг үсэг үл мэдэгчдийн тоо эрс олиширлоо.

Хээл хахууль, хуйвалдаан нийгмийн эмгэг болон архагшив.

Улс орны хувь заяа эгзэгтэй ийм үед "Эх орон-МАШСН" авилга, хуйвалдаан, зохион байгуулалттай, гэмт хэргийг таслан зогсоож, үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг арилгах амаргүй зорилт дэвшүүлж байна.

## Хоёр: Эдийн засгийн зорилт

"Эх орон-МАШСН" үндэсний  
үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлнэ"

### 2.1. Ерөнхий зорилт

**2.1.1.**Хүний хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн Монгол улсын Зүйл Баруун, Дунд, Төв бүсэд экспортын баримжаатай, өмчийн олон хэлбэр сууринсан үйлдвэрлэлийг жигд хөгжүүлэх замаар бус нутаг бүрт эдийн засгийн хувьд бүрэн биеэ даах нөхцөл боломжийг бүрдүүлж, 2004 он гэхэд ДНБ-ийн жилийн дундаж өсөлтийг одоогийнхөос 2 дахин, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг 2-2.5 дахин нэмэгдүүлнэ.

**2.1.2.**Дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, хүн амын өргөн хэрэгжүүлэх бараа үйлчилгээний хангамжийг нэмэгдүүлж, үндэсний мөнгөн тэмдэгийн төгрөгийн ханийг тогтворжуулж, инфляцийн түвшинг нэг оронтой тохиолдлын барина.

**2.1.3.**Гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих улс төр, эрхийн эдийн засгийн таатай нөхцлийг бүрдүүлнэ.

**2.1.4.**Экспортыг нэмэгдүүлж, гадаад худалдааны тэнцлийг сайжруулж,

**2.1.5.**Бус нутгийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлж, өөрийн санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна. Улсын төсвийн зардлын бүтцийг оновчтой болгоно.

**2.1.6.**Бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан татварын бодлогод дурдсан өөрчлөлтийг оруулна. Үүнд:

-үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, дотоод зах зээлийг гадаадын чанарын бараа, бүтээгдэхүүнээс хамгаалах, үйлдвэрлэлд орчин үеийн техникин нэвтрүүлэх сонирхлыг урамшуулах зорилгоор импортын барааны татварыг ялгавартай тогтооно;

-олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрт тохиолдолд татварын хөнгөлөлт үзүүлнэ;

-дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татварын адил тэгшиж хангана;

-мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг дэмжих зорилтуулж экспортын татварын хэмжээг өөрчлөн шинэчилнэ;

-бус нутгийн байршилаас хамаарсан бараа, үйлчилгээний үнэ, таралт ялгааг татварын бодлогоор зохицуулна;

-ашигт малтмалын нөөц, байгалийн баялаг ашигласны төлбөрийн төсөөвт, харин орон нутагт ажиллаж байгаа уурхай, үйлдвэрийн орлогын татварыг тухайн аймаг, сумын төсөөвт төвлөрүүлэх баримтална. Ашигт малтмалын төрөл, орд газрын тогтоц, ашиглалтын

харгалзан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тогтооно.

2.1.7. Гадаадын зээл тусламжийн үр ашгийг дээшлүүлэх, төсвийн орлогын зарцуулалтад хяналт тавьж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг төрилгоор Засгийн газрын банк байгуулна.

2.1.8. Төв банкнаас арилжааны банкны үйл ажиллагаанд тавих тогтолцоог боловсронгуй болгож, хадгаламж эзэмшигч болон тогтолцоог байгууллагын мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаална.

2.1.9. Өмч хувьчлалыг тууштай явуулна. "Эрдэнэт" үйлдвэр, МИАТ, зам, эрчим хүч, "Говь" зэрэг стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн төрийн мэдэлд байлган менежментийг нь сайжруулна.

2.1.10. Өмч хувьчлалын орлогыг зөвхөн хөрөнгө оруулалтад зарцуулна.

## 2.2. Дэд бүтэц

Эдийн засгийн бүс нутгуудыг эрчим хүчиний найдвартай эх Үүсвэрээр зорилт тавьж байна.

2.2.1. Баруун бүсэд: Майхантолгойн УЦС-ыг 2001 онд, Улаанбоомын 2004 онд тус тус ашиглалтад оруулан бүс нутгийг хамгийн хямд хүчээр хангана.

2.2.2. Дунд бүсэд: Чаргайтын УЦС-ыг 2003 онд ашиглалтад оруулахын Баянтээгийн нүүрсний уурхайд түшиглэсэн ДЦС барих ажлыг эхлүүлнэ.

2.2.3. Төв бүсэд: Тавантолгойн нүүрсний уурхайг түшиглүүлэн экспортын алтаар 2-3 сая мгвт-ын хүчин чадалтай ДЦС байгуулах техник, эдийн үндэслэл боловсруулна.

2.2.4. Төвийн эрчим хүчиний системийн найдвартай ажиллагааг хангах оор Эгийн голын УЦС-ыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.2.5. Зүүн бүсэд: Чойбалсангийн цахилгаан станцын оргил ачааллын үед үргтай ажиллагааг нь хангах Баян-Адаргын 8 мгвт-ын УЦС-ыг лна.

2.2.6. Говь, тал хээрийн бүс нутагт нар, салхины эрчим хүчийг өргөн ала. Баруун бүсийн Хөшөөт, Зээгт, Дунд бүсийн Жинст, Баянтээг, Төв Сухайт, Тэвшийн говь, Зүүн бүсийн Шивээ-Овоо, Тал булагийн нүүрсний түшиглэн шахмал түүшний үйлдвэр байгуулж хөдөөгийн айл өрхийг эр хангана.

**-4-**

**2.2.7.**Аймаг бүрт өмчийн олон хэлбэрт сууринсан зам гүүрийн байгууллагын үйл ажиллагааг тогтолцожуулж, Өвөрхангай-Баянхонгор Хархорин-Цэцэрлэг, Эрдэнэ-Багануурын хатуу хучилттай авто замыг тавинш

**2.2.8.**Улс, орон нутгийн чанартай төмөр замын сүлжээ байгуулж техник-эдийн засгийн үндэслэл боловсруулж дуусгана.

-Тавантолгойн нүүрсний уурхайг Даланзадгадын ДЦС-тай төмөр замаархолбоно.

**2.2.9.**Аймгуудын нисэх буудлыг сэргээн тохиижуулан, авиа парки шинэчлэн өргөтгөж, Улаанбаатараас эдийн засгийн бүсүүдэд зорчих бол бүсийн дотоодын агаарын тээврийн сүлжээг оновчтой болгоно.

**2.2.10.**Зорчигч, ачаа тээвэр, аялал жуулчлал, спортын зориулалтын авиа компани байгуулах, үйлчлэх талаар хувийн хэвшлийн санал санаачилгын төрөөс дэмжинэ.

**2.3.11.**Далайд гарцигүй орнуудад хөнгөлөлт үзүүлэх олон улсын эрх хүрээнд Монгол улс гадаад далайн баялгаас хувь хүртэх асуудлыг олон улсын холбогдох байгууллагад тавьж шийдвэрлэх, далайн тээвэрт Монгол улсын хөмөнгөц аялуулахыг онцлон анхаарна.

**2.3.12.**Улс болон орон нутгийн чанартай радио, телевиз, холбооны орчин үеийн сүлжээг бий болгоно. Эдийн засгийн Зүүн, Баруун бүсийн аймгуудын интернетийн дотоод сүлжээнд холбоно.

**2.3.13.**Хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх боловсруулна.

### **2.3.Аж үйлдвэр**

Бүс нутаг бүрийг тэнцвэртэй хөгжүүлэх бодлоготой уялдуулан улс орчин эдийн засгийн чадавхийг дээшилүүлж, экспортыг нэмэгдүүлэх аж үйлдвэртэй эрчимтэй хөгжүүлэх зорилт тавьж байна.

**2.3.1.**Баруун бүсэд Байримын нуруу, Завханы Алтайн өвөр өвлийн геологийн судалгааг эрчимжүүлж, өнгөт үнэт металлын 2-3 ордыг ашиглалтад оруулна.

-Дэлхийн зах зээлийн эрэлт, дотоодын хэрэгцээтэй уялдуулан Асгатын монгө, Улаан-Уул, Ховд голын гянтболд, Бидэрийн голын магнезитийн орчин ашиглах арга замыг идэвхтэй хайна.

**2.3.2.**Дунд бүсэд Бүрэнхааны фосфоритын ордыг ашиглана. Хоногийн орчмын хөнгөн цагааны ордыг судалж, ашиглах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулж дуусгана. Булган, Архангай, Хөвсгөл аймгийн нутгийг хамарахад өнгөт, үнэт металлын хэтийн төлөв бүхий 30 гаруй мян.км<sup>2</sup> талбарын

10000-ын масштабын геологийн зураглал, эрлийн ажил хийнэ. Байдрагийн  
ны сав газарт эрэл хайгуулын иж бүрэн судалгаа хийнэ.

2.3.3. Төв бүсийн алт олборлох, зэс молибден баяжуулах үйлдвэрлэлийн  
түвшинг хадгална. Харморьтын тугалга, Цагаан давааны гянтболд  
бусад ордыг ашиглах боломжийг судална.

-Дундговь аймагт ураны орд ашиглана.

-Дарханы хар төмөрлөгийн ойролцоо байгаа Төмөртэй, Баянгол,  
Төмөртолгойн төмрийн ордыг ашиглахыг зорино.

2.3.4. Зүүн бүсэд хайлуур жонши олборлох, боловсруулах үйлдвэрийн хүчин  
долын өнөөгийн түвшинг хадгална. Цагаансуваргын зэс, Луугийн голын ховор  
цемент, Улаан, Цав, Төмөртэйн холимог металлын ордыг ашиглахад гадаад  
тодоны хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай нөхцөл бүрдүүлнэ.

-Өндөрцагааны гянтболд, Монгөн-Өндөрийн мөнгө, Цагаанчууутын  
молибдены ордыг түшиглэн аж үйлдвэрийн бүтэц бий болгоход анхаарна.

2.3.5. Эрдсийн түүхий эдийн байрилаас хамаарч эдийн засгийн бүс бүрт  
цемент, төмөр бетон, тоосго, хүрмэн блокын үйлдвэрийг барьж байгуулна.  
Ухайлбал Ховд, Говь-Алтай, Хөвсгөл, Баянхонгор, Дархан-Уул, Дорнговь,  
Дорнод аймагт цемент, барилгын материалын үйлдвэрийг 2000-2004 онд  
байгуулах, сэргээн шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. Аймаг болон сум дундын  
жижиг үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжинэ.

2.3.6. Эдийн засгийн бүс нутаг бүрт ноос, ноолуур боловсруулах орчин  
үеийн технологитой үйлдвэр байгуулж, экспортын эцсийн бүтээгдэхүүн  
үйлдвэрлэнэ.

2.3.7. 2004 он гэхэд бүс нутаг бүрт ажиллаж байгаа гурилын үйлдвэрийг  
шинэчлэн өргөтгөнө.

#### 2.4. Мал аж ахуй

Мал аж ахуйн салбарыг үр ашгийг дээшилүүлэх явдлыг гол зорилт болгон  
тавьж байна.

2.4.1. Монгол орны бэлчээрийн даацаад тохирсон, ашиг шим сайтай мал  
аж ахуйг хөгжүүлэх сонирхлыг малчдад бий болгох талаар төрөөс зохицуулалт  
хийнэ.

2.4.2. Нутгийн шилдэг омгийн малыг сонгон үржүүлж, сүү, мах, ноосны  
тиглэлийн үүлдрийг түлхүү өсгөн мал аж ахуйн бүтээгдэхүүний тоо хэмжээ,  
чанарыг нэмэгдүүлнэ.

2.4.3. Монгол орны онцлогт тохирсон зоо, мал эмнэлгийн оновчтой  
бүтцийг бий болгоно.

2.4.4. Тахиа, гахай, зөгий, загасны аж ахуйг хөгжүүлж, хүнсний нэр  
төрлийг олируулна.

**2.4.5. Мал аж ахуйн салбарт зах зээлийн нөхцөлд зохицсон шинж хэлбэрийн хоршон аж ахуй байгуулах санал санаачилгыг бүх талаар дэмжин**

**2.4.6. Байгалийн хадлан бэлтгэх арга ажиллагааг боловсронгуй болжилд 1.2-1.5 сая тонн хадлан бэлтгэж, малын тэжээл тариалах ажлын эрчимжүүлэн, мал сургийг байгалийн эрсдлээс хамгаална.**

## *2.5. Газар тариалан*

Эх орны үйлдвэрийн гурил, хүнсний ногоогоор дотоод хэрэгцээний эхийн хангах зорилт тавьж байна.

2.5.1.2004 он гэхэд газар тариалангийн эргэлтийн талбайг 700 мяанган га-д хүргэж жилд дунджаар 450-500 мяанган тонн үр тариа хүртэвч, 250-300 мяанган тонн гурит үйлдвэрлэнэ.

2.5.2. Эх орны болон манай оронд нутагшиж болох сортын үрийн (super элит, элит үр) бий болгон, үйлдвэрлэлд өргөн хэрэглэх арга хэмжээ

**2.5.3.Хавж элдэншүүлэх, цомхотгосон элдэншиүүлэг, тэг элдэншүүлэг дэвшилтэт технологийн шаардлагад тохигох хөрс хамгааллын техникээр хөдөө аж ахуйн паркийг шинэчилнэ.**

#### **2.5.4.Хүнсний ногоогоор дотоод хэрэгцээссээ бүрэн хангана.**

## *2.6.Аялал жуулчлал*

Аялал жуулчлалыг төсвийн орлогыг бүрдүүлэхэд томоохон хувь НЭР оруулдаг салбар болгон хөгжүүлэх зорилт тавьж байна.

**2.6.1.Хүжирт, Шаргалжуут, Онон, Ноёнхангай зэрэг халуун раша түшиглүүлэн байгалийн эмчилгээ, сувилгааны байнгын ажиллагаатай ижүүлчлалын бааз байгуулах, хуучин баазуудыг шинэчлэн тохиижуулж хэмжсээ авна.**

**2.6.2.Аялал жуулчлалын хангамж үйлчилгээг орчин үеийн түүх хүргэнэ.**

**2.6.3. Байгалийн бүс бүслүүрийн онцлогийг харгалзан Ховс бол Дархадын хотгор, Хорго, Эхийн гол, Говь Гурван сайханд байгалийн эжуулчлалын отог байгуулж, үйлчилгээг сайжруулна.**

## *Гурав. Нийгмийн зорилт*

*"Эх орон-МАШИН" ядуурлыг ариалж*

Монгол улсын хөгжлийн гол эх сурвалж хийгээд туйлын зорилгоо хөгжил мөн. Хүн ам мэдлэг боловсролтой, эрүүл Энх байх нь хүний хангах чухал нөхцөл гэж үзэж байна.

### **3.1. Боловсрол**

Боловсрол нь хөгжлийн үндэс, түүний хурдасгуур гэдэг зарчмыг баримтлан боловсролын үйлчилгээний чанар, үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

**3.1.1.** Бүх шатны сургууль, цэцэрлэгийн барилга, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, сургалтын орчинг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг эс нэмэгдүүлж, сургалтын хэвийн материаллаг орчин бүрдүүлэхийг тэргүүн элжинд авч үзнэ.

**3.1.2.** Бүх шатны сургуульд үндэстний соёл, ёс заншлын мэдлэг, хүмүүжилжгох, суралцаасداد эх оронч үзэл төлөвшүүлэхэд онцлон анхаарна.

**3.1.3.** Бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалтай уялдуулан багши бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшилүүлэх тогтолцоог сургууль, аймаг, бус нутаг, улсын хамжээний гэсэн бүтэцтэйгээр бий болгон тасралтгүй ажиллагааг нь хангана.

**3.1.4.** Дээд боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлэн түүний эрдэм шинжилгээний хүч нөөцийг нэмэгдүүлэх, санхүүжилтийг боловсронгуй болгох арга замаар тогтвортой хөгжлийн суурийг тавьж, олон улсад хүлээн ювшөөрөгдөх сургалтыг явуулах талаар дэс дараатай арга хэмжээ авна.

**3.1.5.** Техникийн болон мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн хүрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн хөгжүүлэх бодлого баримтална.

**3.1.6.** Хүүхдийг б наснаас нь эхлэн сургуульд сургах бэлтгэлийг хангахын хамт сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

**3.1.7.** Боловсрол дахь хувийн хэвшилийн оролцоог татварын бодлогоор дэмжиж, нийтлэг мөрдөж байгаа стандартын шалгуураар үнэлгээ өгч, чанар муутай сургалтаас зайлсхийх бололцоо нөхцөлийг иргэддээ олгоно.

**3.1.8.** Албан бус боловсрол, зайндын сургалт зэрэг үр ашигтай шинэ хэлбэрийг дэмжин хөгжүүлж, боловсролын тогтолцооны бүтцийг боловсронгуй болгоно.

**3.1.9.** Авьяас билэгтэй, оюуны өндөр чадавхитай хүүхэд, залуусын сургалтын зардлыг ар гэрийн төлбөрийн чадварыг нь үл харгалзан тор хариуцна.

**3.1.10.** Бус нутаг бүрт орчин үеийн их сургуулийг шинээр байгуулна.

**3.1.11.** Сургууль завсардалтыг таслан зогсоондоо.

### **3.2. Эрүүл мэнд**

Хүн амын дундаж наслалтыг 3-5 жилээр уртасгах зорилт тавьж байна.

**3.2.1.** Иргэд өөрсдөө эрүүл мэндийнхээ төлөө хүлээх хариуцлагыг дээшилүүлэх цогц арга хэмжээ авна.

**3.2.2.**Хүн амын амьдралын ахуй нөхцөлийг сайжруулан, хүнсний чанар дээшилүүлэх замаар ард иргэдийн эруул мэндийг хамгаална.

**3.2.3.**Архи, тамхи хэрэглэх болон бусад хорт зурилын эсрэг өргөн хүрээнд ажил зохион байгуулжс, архи тамхины үйлдвэрлэл, импортыг татварын бодлогын зохицуулна.

**3.2.4.**Төрөлтийг дэмжих эдийн засгийн бодлогыг төрөөс авч хэрэгжүүлийг бурд төрөхийн өмнөх ба дараах амралт, сувилгааны газрыг сэргээн тохижуулна.

**3.2.5.**Хүн амын дунд өргөн тархсан сурьеэ, шар, бруцеллөз, бэлгийн таат халдварт өвчин зэргийг бууруулах, улмаар арилгах ажлыг зохион байгуулна.

**3.2.6.**Орчин үеийн тоног төхөөрөмжтэй оношилгоо, эмчилгээний таат эдийн засгийн бус, дүүрэг бүрт байгуулжс, орон нутагт эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг цоо шинэ шатанд гаргана.

**3.2.7.**Эмч мэргэжилтнийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтууллаа ажиллуулах эдийн засгийн урамшууллын механизм бий болгоно.

**3.2.8.**Ардын уламжлалт анааах ухааны үр нөлөөтэй аргуудыг орчин үеийн анааах ухаантай зохистой хослуулан хөгжүүлэх бодлого баримталжс, үйлдвэрийг өргөжүүлнэ.

**3.2.9.**Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд төрийн бус байгууллагын оролцоо, гүйцэтгэх үүргийг өргөжүүлжс, өмчийн олон хэвшилд сууриссан мэндийн байгууллагын тогтолцоог бүрдүүлнэ.

### 3. 3. Соёл урлаг

Нүүдэлчний өвөрмөц нандин соёл, урлагийн өвийг хадгалан орчин үеийн ололтоор баяжуулан хөгжүүлэх зорилт тавьж байна.

**3.3.1.** Хөдөөд соёл түгэн хөгжих нөхцөл бололцоо бүрдүүлэн соёлын эхийн жуулчилалын олон хэлбэрийг дэмжин хөгжүүлнэ.

**3.3.2.**Уран бүтээлчийн чөлөөтэй сэтгэх, бүтээн түүurvих орчин үеийн бүрдүүлнэ. Соёл урлагийн үйлчилгээний хүрээг өргөжүүлнэ.

**3.3.3.**Сонгодог болон хүүхдэд зориулсан урлагийг төрөөс дэмжин хөгжүүлнэ.

**3.3.4.**Түүх соёлын дурсгалт зүйлс, ардын урлаг, шинжслэх ухаан, мэдээллийн үнэт өв, дэвшилт зан занилыг үндэсний онцгой баялаг гэж үзүүлж, хамгаалалтад байлгана.

-9-

**3.3.5.**Ардын дуу хөгжим, тоглоом наадгай, урлаг болон уран дарханы арга түрээ соёлын өвийг хадгалан өвлүүлнэ.

**3.3.6.**Дизайны урлаг, хот байгуулалт, уран барилгыг үндэсний онцлог байдлаар төгжсүүлнэ.

**3.3.7.**Номын сан, музейн сан хөмрөгийг арвижсуулан үйлчилгээний шинэ хэлбэр, шинэ технологи нэвтрүүлнэ. Сумдын номын санг сэргээн ажиллуулж, үйл ажиллагааг нь тогтмолжсуулна.

#### **3.4.Шинжлэх ухаан технологи**

Шинжлэх ухааны нэгэнт бүрдсэн чадавхийг хадгалан, өсгөн хөгжүүлэхэд тараас дэмжлэг үзүүлжс, эрдэм шинжилгээний ажилд төрийн бус байгууллага, цэвэрээдийн оролцоог өргөжүүлэх эрх зүй, эдийн засгийн хөшүүрэг, механизмуудыг бий болгоно.

**3.4.1.** Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлүүдийг улс орныг бүсчлэн төгжсүүлэх үзэл баримтлал, бутцийн бодлогод нийцүүлэн шинэчлэн тодорхойлж, суурь болон хавсарга судалгаанд зарцуулах хөрөнгийн зохистой харьцааг тогтооно.

**3.4.2.** Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны үр бүтээлтэй ажиллах тохицэл бололцоо, нийгмийн баталгааг хангаж, оюуны болон материалыг бүтээмжийн үр дүнгээр цалинжсуулж урамшуулдаг шударга зарчмыг хэрэгжүүлнэ.

**3.4.3.** Шинжлэх ухаан, технологи, боловсролын тогтолцооны уялдаа холбоог улам оновчтой болгож, шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлээр нарийн мэргэжисэн судлаачид бэлтгэх, залуу эрдэмтдийг дэмжих арга хэмжээ авна.

**3.4.4.** Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн үндэсний нэгдсэн сүлжээ, сан бүрдүүлж төрийн хамгаалалтад авна.

#### **3.5.Ажлын байр, орлого цалин**

**3.5.1.** 2004 он гэхэд ажилгүйдлийг 40 хувиар бууруулж, цаашид бүрэн арилгана.

**3.5.2.** 2004 он гэхэд төсвийн байгууллагад ажиллагчдын цалинг 3 дахин нэмэгдүүлнэ.

**3.5.3.** Эрчим хүчний үнийг хямдруулж, хүн амын бодит орлогыг нэмэгдүүлнэ.

**3.5.4.** Амьжиргааны баталгаажих доод түвшинг жил бүр шинэчлэн тогтоож байна.

### 3.6. Ахмад настан

3.6.1. Ахмад настны тэтгэвэр тэтгэмжийг 3 дахин нэмэгдүүлнэ.

3.6.2. Ахмадаа хүндэлж асрах ардын уламжлалт ёс занилыг бататж хөгжүүлж, шинэ агуулгаар баяжуулна.

3.6.3. Монгол улсын тусгаар тогтолцоол, бүтээн байгуулах үйлсэд онц хувь нэмэр оруулсан алдар гавьяатай хүмүүст үзүүлэх бүх төрлийн хөнгөлж тэтгэмжийг 5 дахин нэмэгдүүлнэ.

3.6.4. Ахмад настны нийтийн унааны болон эм тарианы хэрэгжүүлж зориулж нөхөн олговор олгоно.

3.6.5. Тэтгэврийн насны ахмадуудыг жилд нэг удаа үнэ толбоор эмнэлгийн иж бүрэн үзлэгт хамруулна.

3.6.6. Асран хамгаалах хүнгүй өндөр настанд зориулсан асрамжийн төрөөний болгон төрөөс бүх зардлыг хариуцна.

### 3.7. Хүүхэд, эмэгтэйчүүд

3.7.1. Өрх толгойлсон эмэгтэйчүүдэд байнгын халамж дэмжлэг үзүүлнэ.

3.7.2. Гурваас дээши хүүхэдтэй өрхөд төрөөс тогтмол урамшуулалт үзүүлж байна.

3.7.3. Өнчин, тэнэмэл хүүхдүүдийг төр шууд ивээлдээ авч, нэг ч хүүхдийн орхилгүй сургаж хүмүүжүүлэх арга хэмжээ авна.

3.7.4. Нийгмийн халамж, хамгааллын салбарыг эмэгтэй хүүхэдтэй удирдуулна.

3.7.5. Аймаг, дүүрэг бүрд хүүхдийн номын сан байгуулна.

3.7.6. Хүүхдийн бүх талын хөгжлийг хангах нөхцөл бүрдүүлэх зорилтууд "Хүүхэд-хөгжил" үндэсний цогцолбор хөтөлбөр боловсруулж дэс дараатай хэрэгжүүлнэ.

### 3.8. Залуучууд

3.8.1. Бүс нутаг бүрт залуучуудын спорт, соёлын төв байгуулна.

3.8.2. Залуучуудад ажиллаж амьдрах ая тухтай нөхцлийг бий болгоор орон сууц, удаан эдэлгээтэй ахуйн хэрэгцээний хэрэгслийг оюутнууд мөнгөн хэлбэрээр олгоно.

3.8.3. Нийтийн тээврийн хөнгөлөлтийн нөхөн олговрыг оюутнууд байр бий болгон Хөдөлмөрийн бирж ажиллуулна.

3.8.4. Оюутан сурагчид, түр ажилгүй хүмүүст зориулан цагийн ажлын байр бий болгон Хөдөлмөрийн бирж ажиллуулна.

3.8.5. Оюутны дотуур байрны ахуй нөхцлийг сайжруулж, зардлыг төрөөний хариуцна.

### 3.9. Нийгмийн үйлчилгээ

3.9.1. Бүх аймгийн төв, нийслэлийн гэр хороололд халуун усны асуудлыг шийдвэрлэнэ.

-11-

**3.9.2.**Хөдөөгийн иргэдийн телевиз, радио, хэвлэлийн хангамжийг сайжруулна. Малчдыг гар утастай болгон холбоожуулна.

**3.9.3.**Говийн аймгуудын ялангуяа Сүхбаатар, Говь-Алтай аймгийн усан хангамж, ундны усны асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

**3.9.4.**Хот, суурин газрын гэр хорооллын иргэдэд газар эзэмших эрхийг б0-иас доошигүй жилээр олгож, тогтворт суурьшилтай амьдрах баталгааг хангана.

**3.9.5.**Оршин суугчдын амгалан тайван, аюулгүй байдлыг ханган, орон сууцны харуул хамгаалалт, орчны тохиижилтыг шийдвэрлэнэ.

**3.9.6.**Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу орчин үеийн бичил хороолол үүсч хөгжих санхүү зээлийн таатай нохцөл бүрдүүлнэ.

#### Дөрөв. Улс төрийн зорилт

"Эх орон-МАШСН" авилга,  
хуйвалдааныг таслан зогсоон.

Төрийн байгууллагуудын ажлын уялдааг сайжруулж, ажил хэрэгч, шуурхай шинжийг дээшлүүлэн, авилга, хуйвалдааныг арилгахад голлон шийхаарна.

**4.4.1.**Засгийн газрын агентлагуудын ажлын давхардлыг арилгаж, тоог цөөлнө. Зарим агентлагийн үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлнэ.

**4.4.2.**Яамдыг үйл ажиллагааны чиглэлээр ажиллуулж, мэргэжлийн хүнээр удирдуулна.

**4.4.3.**Төр засгийн боловсон хүчинийг шилж сонгоходоо намын харьяаллыг бус, мэргэжлийн чадварыг эн тэргүүнд чухалчлан үзнэ.

#### 4.2. Авилга, хээл хахууль, хуйвалдааныг арилгаж, гэмт хэргийг бууруулах

**4.2.1.**Бүх төрлийн лиценз зөвшөөрөл олгодог журмыг хялбар болгон тоог цөөрүүлж, шат дамжлага, чирэгдлийг арилган, хөндлөнгийн хяналтыг хүчтэй болгоно.

**4.2.2.**Прокурор, бүх шатны шүүгчид бусдын нөлөөнд автажгүй байх тохицлийг бүрдүүлж, амьдралын баталгааг нь хангана. Төрийн албан хаагчдын албан тушаал ахихын хэрээр илүү хариуцлага хүлээдэг зарчмыг хэвшүүлнэ.

**4.2.3.**Хоорондоо зөрчилтэй хууль, тогтоомжуудыг нэгтгэн цэгцэлж улдаа холбоог нь хангана. Хуулийн хэрэгжилтэд тавих бүх шатны хяналтыг индоржүүлнэ.

**4.2.4.**Гэмт хэргийн тоог эрс бууруулж, зохион байгуулалттай гэмт хэрэг тарах нийгэм, эдийн засгийн үндсийг арилгана.

**4.2.5.**Хорих ял эдлэгчдээр ажил хөдөлмөр хийлгэн иргэд болон нийгмийг үйлийн засгийн хувьд хохиролгүй болгох чиглэлийг голлон баримтална.

**4.2.6.** Ард түмнээ үнэн бодит мэдээллээр хангадаг чөлөөт хэвлэлийн дэмжинэ.

#### **4.3. Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх**

**4.3.1.** Нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг эрхэмлэнэ.

**4.3.2.** Хөрш хоёр улстайгаа тогтоосон уламжлалт харилцааг хүндэтгэх, үзэж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

**4.3.3.** Үндэсний аюулгүй байдлыг хангах гол арга зам нь өөрийгөө тэтгэх хүчтэй эдийн засгийг бүрдүүлэх явдал гээж үзнэ.

**4.3.4.** Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг оновчтой болгож, улс төрийн намуудын харилцаанд үндэсний язгуур эрх ашиг, эв нэгдлийн төлөө зөвшүүлэх, ойлголцох зарчмыг чухалчлан үзнэ.

**4.3.5.** Хилийн цэргийн мэргэжлийн чадварыг дээшлүүлж, зэвсэг техникийн хил хамгаалалтыг хамгийн орчин үеийн түвшинд шийдвэрлэнэ. Цомхон чадварлаг, мэргэжлийн зэвсэгт хүчинийг бий болгох бодлогыг баримтална.

**4.3.6. Хүн амынхаа хүнсний аюулгүй байдлыг хангана.**

#### **Хүндэт сонгогчид өө!**

- Та бид баян орны иргэд атлаа ядуу амьдрах хэрэг юун. Хийж бүтэц цаг болсон. Бид хошуучлан хийх болноо.
- Монголд чадварлаг төр хэрэгтэй. Монголын төрийг авилан хуйвалдаанаас аврах цаг болсон. Шударга хүн бүр үүн дээр нэгдээгүйн чадварыг дээшлүүлж, зэвсэг техникийн хил хамгаалалтыг хамгийн орчин үеийн түвшинд шийдвэрлэнэ. Цомхон чадварлаг, мэргэжлийн зэвсэгт хүчинийг бий болгох бодлогыг баримтална.
- Шинэ зуун, шинэ мянган эхэлж байна. Бид алийн болгон хуучин санагалзаж, улиг домог болсон хуучин хүмүүсийг гаргах юм бэ.

**Шинэ**

**Шударга**

**Бүтээлч**

**Улс төрийн хүчин**

"Эх орон-МАШСН"-ыг дэмжисж, улс орноо хамтдаа хөгжүүлэн, өөрсдүүн сайхан амьдарцаа.